ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 22 өдөр Дугаар А/141 Баянтал сум

Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн
хүүгийн орлого зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, ХХААХҮСайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын "Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх хяналт тавих журам"-ын 2.7 дах заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сангаас олгосон зээлийн хүүгийн өмнөх жилийн орлогын 50 хүртэл хувийг хууль тогтоомжид нийцүүлэн захирамжийн хавсралтын дагуу зарцуулахыг зөвшөөрсүгэй.

2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагдсан хүүгийн орлого 2400000 (хоёр сая дөрвөн зуун мянга )төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангаас зарцуулахыг Нягтлан бодогч / Б.Солонгомаа /-д зөвшөөрсүгэй

3.Сангийн зээлийн хүүгийн орлогын зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Хоршоо хөгжүүлэх сангийн хяналтын хорооны дарга (Х.Мөнхбаатар )-т үүрэг болгосугай

ДАРГА Б.ГАНБАЯР

Сумын Засаг даргын 20 24 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн

А/41 дугаар захирамжийн 01-р хавсралт

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн орлогын зарцуулалт

| № | Зардлын ангилал | Мөнгөн дүн |
|---|---|---|
| 1 | Сургалт сурталчилгаа | 1200000 |
| 2 | Программ хангамж | 510000 |
| 3 | Төслийн үр дүн, хяналт шалгалт | 340000 |
| 4 | Хоршоо хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн урамшуулал | 350000 |
| | Нийт / төгрөг / | 2400000 |